ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Монгол улсын сайд, боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2024/38/НА-СТА-ТЕЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br><br>Улаанбаатар хот<br>2024 он | Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг<br>Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: П.Чанцалдулам<br>Утас: 260949 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Э.Энхбаатар<br>Утас: 261628 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn<br>Аудитор: Т.Баасанцэнд<br>Утас: 261628 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1147

танай ____________-ны № ____________-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, БООМТЫН СЭРГЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА Б.ТУЛГА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол улсын сайд, боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол улсын сайд, боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын засгийн газрын 2023 оны 196 дугаар тогтоолоор боомтын сэргэлтийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг өөрчлөн баталсан байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд Монгол-Хятадын хилийн боомтын менежментийн 5 дугаар хуралдааныг зохион байгуулж, Замын-Үүд боомтын ачаа тээврийг 24 цагийн горимд шилжүүлж, боомтын сэргэлтийн үндэсний хорооны хуралдаанаар Ховд аймгийн Булган боомтод ачаа тээврийн шинэ гарц байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэрийг гаргасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Засгийн газрын бодлого шийдвэр, боомтын сэргэлтийн үндэсний хорооны тогтоолыг хэрэгжүүлэх, биелэлтийг зохион байгуулах хууль сахиулах болон Хилийн хяналтын байгууллага орон нутгийн засаг захиргааны байгууллагын ажлын уялдаа холбоог нэгдсэн зохион байгуулалтаар хангаж ажилласан байна.

Z:\Yawsan_Bichig\2024\0425 SNAG-20.Docx

0001030784

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЗАГДЖАВ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | - | 568,504.9 |
| 33 | АВЛАГА | - | 17,926.3 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | - | 550,578.6 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | - | 33,814,044.2 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | - | 33,814,044.2 |
| 39200 | Биет хөрөнгө | - | 33,813,177.5 |
| 39300 | Биет бус хөрөнгө | - | 866.7 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | - | **34,382,549.1** |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | - | 34,382,549.1 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | - | 34,382,549.1 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | - | 34,382,549.1 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | - | **34,382,549.1** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | - | **5,721,577.9** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | - | **47,192.0** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 47,192.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | - | 5,674,386.0 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | - | **10,282,230.3** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 10,282,230.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 8,299,129.6 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | - | 1,308,400.9 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | - | 149,173.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | - | 149,473.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 388,006.2 |
| 2105 | Нормативт зардал | - | 17,332.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | - | 188,783.5 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 396,934.6 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 796,851.2 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 4,904,173.4 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 1,983,100.6 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | - | **(4,560,652.4)** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | **26,635.9** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | - | **(4,587,288.4)** |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/мянган төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **-** | **5,674,385.9** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **-** | **5,674,385.9** |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **5,393,144.1** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 5,393,144.1 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 3,410,043.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | - | 1,308,671.3 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | - | 149,173.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | - | 149,473.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 422,393.4 |
| 2105 | Нормативт зардал | - | 39,715.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | - | 343,932.5 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 396,646.4 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 497,698.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 102,339.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 1,983,100.6 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **-** | **281,241.8** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **-** | **281,241.8** |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 281,241.8 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 281,241.8 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-** | **(281,241.8)** |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/мянган төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | - | - |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 38,969,837.4 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | 38,969,837.4 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | (4,587,288.4) |
| **20** | **2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | - | - | **34,382,549.1** |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,700,409,000.00** | **3,691,285,276.55** | **2,009,123,723.45** | **64.8** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,700,409,000.00** | **3,691,285,276.55** | **2,009,123,723.45** | **64.8** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,700,409,000.00** | **3,691,285,276.55** | **2,009,123,723.45** | **64.8** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,438,375,400.00** | **1,308,671,324.05** | **129,704,075.95** | **91.0** |
| Үндсэн цалин | 969,765,700.00 | 718,279,343.53 | 251,486,356.47 | 74.1 |
| Нэмэгдэл | 391,015,600.00 | 319,901,481.92 | 71,114,118.08 | 81.8 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 55,440,000.00 | 94,514,000.00 | (39,074,000.00) | 170.5 |
| Урамшуулал | 22,154,100.00 | 175,976,498.60 | (153,822,398.60) | 794.3 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **186,779,700.00** | **149,173,701.99** | **37,605,998.01** | **79.9** |
| Тэтгэврийн даатгал | 120,968,600.00 | 86,940,385.59 | 34,028,214.41 | 71.9 |
| Тэтгэмжийн даатгал | 19,556,300.00 | 16,580,741.59 | 2,975,558.41 | 84.8 |
| ҮОМШӨ-ний даатгал | 12,024,200.00 | 13,209,541.59 | (1,185,341.59) | 109.9 |
| Ажилгүйдлийн даатгал | 2,876,700.00 | 6,261,786.40 | (3,385,086.40) | 217.7 |
| Эрүүл мэндийн даатгал | 31,353,900.00 | 26,181,246.82 | 5,172,653.18 | 83.5 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **296,513,700.00** | **149,473,449.00** | **147,040,251.00** | **50.4** |
| Гэрэл, цахилгаан | 39,075,300.00 | 0.00 | 39,075,300.00 | 0.0 |
| Түлш, халаалт | 28,953,900.00 | 0.00 | 28,953,900.00 | 0.0 |
| Цэвэр, бохир ус | 20,771,200.00 | 0.00 | 20,771,200.00 | 0.0 |
| Байрны түрээс | 207,713,300.00 | 149,473,449.00 | 58,239,851.00 | 72.0 |
| **Хангамж, бараа материалын зардал** | **494,062,200.00** | **422,393,347.96** | **71,668,852.04** | **85.5** |
| Бичиг хэрэг | 23,607,900.00 | 18,294,595.00 | 5,313,305.00 | 77.5 |
| Тээвэр, шатахуун | 411,058,600.00 | 352,819,306.00 | 58,239,294.00 | 85.8 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 15,806,800.00 | 15,482,406.96 | 324,393.04 | 97.9 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,057,400.00 | 0.00 | 7,057,400.00 | 0.0 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 36,531,500.00 | 35,797,040.00 | 734,460.00 | 98.0 |
| **Нормативт зардал** | **41,837,700.00** | **39,715,000.50** | **2,122,699.50** | **94.9** |
| Хоол, хүнс | 17,434,400.00 | 15,902,200.50 | 1,532,199.50 | 91.2 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 24,403,300.00 | 23,812,800.00 | 590,500.00 | 97.6 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **709,822,600.00** | **624,174,301.00** | **85,648,299.00** | **87.9** |
| Багаж, техник, хэрэгсэл | 265,487,600.00 | 234,200,917.00 | 31,286,683.00 | 88.2 |
| Тавилга | 70,000,000.00 | 65,881,435.00 | 4,118,565.00 | 94.1 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 32,950,400.00 | 21,450,000.00 | 11,500,400.00 | 65.1 |
| Урсгал засвар | 341,384,600.00 | 302,641,949.00 | 38,742,651.00 | 88.7 |
| **Томилолт, зочны зардал** | **519,489,200.00** | **396,646,408.80** | **122,842,791.20** | **76.4** |
| Гадаад албан томилолт | 309,500,000.00 | 297,591,758.80 | 11,908,241.20 | 96.2 |
| Дотоод албан томилолт | 209,989,200.00 | 99,054,650.00 | 110,934,550.00 | 47.2 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,804,931,800.00** | **498,698,536.26** | **1,306,233,263.74** | **27.6** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,737,617,100.00 | 454,617,981.26 | 1,282,999,118.74 | 26.2 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,617,300.00 | 0.00 | 1,617,300.00 | 0.0 |
| Даатгалын үйлчилгээ | 13,722,800.00 | 12,207,180.00 | 1,515,620.00 | 89.0 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 3,504,200.00 | 494,925.00 | 3,009,275.00 | 14.1 |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 808,700.00 | 132,000.00 | 676,700.00 | 16.3 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 46,681,500.00 | 31,182,450.00 | 15,499,050.00 | 66.8 |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 980,200.00 | 64,000.00 | 916,200.00 | 6.5 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **208,596,700.00** | **102,339,206.99** | **106,257,493.01** | **49.1** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 200,104,600.00 | 97,959,206.99 | 102,145,393.01 | 49.0 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,492,100.00 | 4,380,000.00 | 4,112,100.00 | 51.6 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **5,700,409,000.00** | **3,691,285,276.55** | **2,009,123,723.45** | **64.8** |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **5,700,409,000.00** | **3,691,285,276.55** | **2,009,123,723.45** | **64.8** |
| Улсын төсвөөс санхүүжих | 5,700,409,000.00 | 3,691,285,276.55 | 2,009,123,723.45 | 64.8 |
| **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **85** | **85** | **-** | **100.0** |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | **-** | **100.0** |
| Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100.0 |
| **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **5** | **5** | **-** | **100.0** |
| Удирдах ажилтан | 5 | 5 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | - | - | - | 100.0 |
| **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **5** | **5** | **-** | **100.0** |
| Ажлын албаны албан хаагч (АА) | 5 | 5 | - | 100.0 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Монгол улсын сайд, боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 1 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдэж, “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

**Харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил**

Монгол улсын сайд, боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 2,616.7 сая төгрөгийн 1 алдааг[1] залруулж, 1,457.6 сая төгрөгийн зөрчилд[2] 2 зөвлөмж өгсөн байна.

**Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дугаар заалтын дагуу иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 54 дүгээр зүйлийн 54.4.1-д “Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан”, 4.5.3-д “тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл”, 54.5.4. "хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/" гэсэнтэй нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитаар нийт 2,616.7 сая төгрөгийн 1 алдаа[3] илэрснийг аудитын явцад залруулсан.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДААНЫ НЭГТГЭЛ** | | | | | | | | | | | |
| **ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ** | | | | | | | | | | | |
| 1 | Хилийн боомтын захиргаа | 1 | 2,616.7 | 1 | 2,616.7 | | | 1 | 2,616.7 | | |
| | **Дүн** | **1** | **2,616.7** | **1** | **2,616.7** | | | **1** | **2,616.7** | | |

Аудитаар нийт 1,457.6 сая төгрөгийн зөрчил[4] илэрснээс 1,457.6 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо |
| **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ** | | | | | | | | | | | |
| **ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ** | | | | | | | | | | | |
| 1 | Хилийн боомтын захиргаа | 2 | 1,457.6 | | | | | 2 | 1,457.6 | | |
| | **Дүн** | **2** | **1,457.6** | | | | | **2** | **1,457.6** | | |

[3] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[4] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 албан шаардлага өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой** | | | | | | | | | | | | | |
| 1 | Монгол улсын сайд, боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| | **Дүн** | **1** | **-** | | | **1** | **-** | | | | | | |